



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 9/05

Бөхт

“Уяхан замбуу тивийн наран” 3000 морин хуурчид,
уртын дуучдын бэлтгэл ажлыг хангах ажлын
хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, “Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай” Ерөнхийлөгчийн 2002 оны 17 дугаар зарлиг, “Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай” Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2.6.3.4, 3.4.5, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Уяхан замбуу тивийн наран” 3000 морин хуурчид, уртын дуучдын бэлтгэл ажлыг хангах зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Монгол ардын уртын дуу “Уяхан замбуу тивийн наран”, “Энхмэндийн баяр”, “Оломгүй далай”, морин хуурын аялгуу “Дундговийн магтаал”, “Миний нутгийн бараа”, “Төв халх жонон” зэрэг бүтээлүүдийг оролцогчдод зааж сургах ажлыг өрнүүлэн, хуурчдыг морин хуураар хангахад санаачилга гарган ажиллахыг албан байгууллагуудын удирдлага, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

3. “Уяхан замбуу тивийн наран” 3000 морин хуурчид, уртын дуучдын бэлтгэл ажлыг хангах зохион байгуулах ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын чиг үүргийг тодорхойлж, ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Л.Мөнхбадрах)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ

Сумын Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 17-ны өдрийн А/55
дугаар захирамжийн хавсралт



“УЯХАН ЗАМУУ ТИВИЙН НАРАН” 300 МОРИН ХУУРЧИД, УРТЫН ДУУЧДЫН
БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Л.Мөнхбадрах (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Т.Мөнхцэцэг (Соёлын төвийн даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн ахлагч	Л.Мөнхбадрах	(Засаг даргын орлогч)
Орлогч дарга	О.Амгалантөр	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд:	Б.Амгаланжаргал	(ЗДТГ-ын дарга)
	Х.Хундмаа	(Санхүүгийн албаны дарга)
	Н.Дэлгэрсайхан	(Сургуулийн захирал)
	Д.Номин-Эрдэнэ	(Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)
	Д.Эрдэнэчулуун	(Эрүүл мэндийн төвийн дарга)
	М.Цэвэгдорж	(Бөхт багийн Засаг дарга)
	Д.Шинэбаяр	(Талын нар багийн Засаг дарга)
	Э.Сумьяа	(Цог багийн Засаг дарга)
	Э.Ёндонпэрэнлэй	(Хэсгийн төлөөлөгч)